ДУНДГОВЬ АЙМАГ
**ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 03 өдөр Дугаар А/67 Амардалай

"Дуут хавдар"-ын өвчнөөс урьдчилан сэргийлэх,
дархлаажуулалтад хамруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн (а) , Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6 дахь заалтуудыг тус, тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын халдварт өвчний гаралт, оношилгоо, судалгаанд тулгуурлан, голомтын бүс нутагт хамрагдах, өрхийн үхэрт дуут хавдрын өвчнөөс урьдчилсан сэргийлэх дархлаажуулалтад хамруулсугай.

2. МЭНС-ийн төлөвлөгөөнд хамрагдсан малчин өрхийн үхэрт дархлаажуулалтад хамруулах товыг багийн Засаг дарга нараар хүргүүлж, дархлаажуулалтыг графикт хугацаанд нь чанартай хийж, гүйцэтгэхийг "Дэлгэрбаяндалай" мал эмнэлгийн нэгжийн эмч М.Даваацэрэнд даалгасугай.

3. Дархлаажуулалтын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга Д.Наранцэцэгт үүрэг болгосугай

ДАРГА М.БАЯРСҮХ